



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны сарын өдөр

Дугаар А/578

Улаанбаатар хот

┌ Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар ┐
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 9,044,212.54 /есөн сая дөчин дөрвөн мянга хоёр зуун арван хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэг /Д.Оюунцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 5 нэр төрлийн 1,214,782.54 /нэг сая хоёр зуун арван дөрвөн мянга долоон зуун наян хоёр төгрөг тавин дөрвөн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 12 нэр төрлийн 7,829,430 /долоон сая найман зуун хорин есөн мянга дөрвөн зуун гуч/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэг /Д.Оюунцэцэг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-т даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/503 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



М.БАЯРАА

115060001628

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/58 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 105 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
Машин , тоног төхөөрөмж											
1	канон /Оюун/	12	ш	1	1,099,900.00	1,099,900.00	1,099,900.00	-	эвдэрсэн	актлах	татах
2	факсын аппарат /Оюун/	12	ш	1	349,900.00	349,900.00	349,900.00	-	эвдэрсэн	актлах	татах
3	хөргөгч	9	ш	1	720,000.00	720,000.00	720,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
4	компьютер	10	ш	1	777,700.00	777,700.00	777,700.00	-	эвдэрсэн	актлах	татах
5	принтер/ CANON-6000/	8	ш	5	259,990.00	1,299,950.00	1,299,950.00	-	эвдэрсэн	актлах	татах
6	телевизор /sky worth/	9	ш	1	420,000.00	420,000.00	420,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
7	тоос сорогч	6	ш	1	199,990.00	199,990.00	199,990.00	-	эвдэрсэн	актлах	татах
8	тоос сорогч	6	ш	1	169,000.00	169,000.00	169,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
9	хөгжим	6	ш	1	95,000.00	95,000.00	95,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
10	том канон /RECON/	8	ш	1	1,549,000.00	1,549,000.00	1,549,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
Машин, тоног төхөөрөмжийн дүн				14		6,680,440.00	6,680,440.00	-			
Тавилга, эд хогшил											
1	хүүхдийн ширээ	12	ш	4	80,000.00	320,000.00	320,000.00	-	эвдэрсэн	актлах	устгах
2	хүүхдийн сандал	12	ш	28	20,000.00	560,000.00	560,000.00	-	эвдэрсэн	актлах	устгах
3	хүүхдийн ширээ богино	9	ш	3	77,000.00	231,000.00	231,000.00	-	эвдэрсэн	актлах	устгах
4	шалны дроз	8	ш	10	95,000.00	950,000.00	950,000.00	-	эвдэрсэн	актлах	татах
5	булангийн буйдан	22	ш	1	198,990.00	198,990.00	198,990.00	-	эвдэрсэн	актлах	татах
6	ширээ 2 сандалтай	13	ш	1	54,943.77	54,943.77	54,943.77	-	эвдэрсэн	актлах	устгах
7	ширээ 2 сандалтай ком	13	ш	1	48,838.77	48,838.77	48,838.77	-	эвдэрсэн	актлах	устгах
Тавилга, эд хогшлын дүн				48		2,363,772.54	2,363,772.54	-			

Нийт данснаас хасах хөрөнгийн дүн	62	-	9,044,212.54	9,044,212.54	-	
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө	25		7,829,430.00	7,829,430.00	-	
Актлах хөрөнгө	37		1,214,782.54	1,214,782.54	-	